

**“Хай Би Ойл” ХК-ийн 2015 оны хагас жилийн
үйл ажиллагааны тайлан**

Нэр: “Хай Би Ойл” ХК

Хаяг: Улаанбаатар хот, СХД, 20-р хороо, Сонсголонгийн /18135/ 110

Утас: 99098989

Улсын бүртгэлийн мэдээлэл: Улсын бүртгэлийн № 9010001063, регистр № 2615134

Үйлдвэрлэл, борлуулалтын тухайд:

2015 оны эхний хагас жилд тосны үйлдвэрлэл болон боловсруулах тоног төхөөрөмжид онцын ноцтой буюу гэнэтийн гэмтэл зөрчил гараагүй жигд, хэвийн ажиллаж байна. Тайлант хугацаанд бид 110’800 литр үндсэн түүхий эдийг гэрээтэй байгуулага болон хувь хүнээс цуглуулж, өмнөх оны үлдэгдлийн хамт нийтдээ 583’064 л түүхий эд цуглуулж авсан. Үүнээс 92’354,65 л бохир тосыг дахин боловсруулалтанд оруулж НӨАТ ороогүй үнээр нийтдээ 76’251’174.0 төгрөгийн мазутын борлуулалт хийгээд байна. 2015 оны эхний хагас жилийн борлуулалтыг өмнөх оны эхний хагас жилийн хугацаатай харьцуулвал 3 дахин буурсан. Энэ нь улсын төсөв батлагдахгүй удсанаас үүдэн зам болоод барилгын ажлууд хожуу эхэлсэнтэй холбоотой гэж үзэж байгаа. Цаашид 7 сарын 20-ноос хойш мазутын борлуулалт ихсэх хандлагатай байгаа болно. Тиймээс бид шаардлагатай түүхий эдийг нөөцөлж бэлтгэхэд анхаарлаа хандуулж байна.

Түүхий эдийг татан төвлөрүүлэхтэй холбоотой “Оюу толгой” ХХК-ны хаягдал тос нийлүүлэгчийн сонгон шалгаруулалтад оролцож, эцэслэсэн дүгнэлт гараагүй байгаа тул манайд тодорхойгүй хугацаагаар хаягдал тос нийлүүлэхийг 5 сараас хойш зогсоосон болно. 2015.06.30-ны өдрийн байдлаар түүхий эд болон боловсруулсан бүтээгдэхүүний нөөц дараах байдалтай байна.

Түүхий эдийн нөөц 372’217 литр

Боловсруулсан тос /Мазут/ 98’117 литр

Хөрөнгө оруулалт, засаж сайжруулсан зүйлс:

Байнгын ашиглагддаг зарим түлхүүр багаж, худгийн насос, цахилгаан тоолуур, гүйдлийн трансформатор, ажилчдын хоолны хэрэглэлүүдийг шинэчилж үүнд нийт 1’585’300₮ төгрөгийг зарцуулсан. Мөн ажилчдын аюулгүй ажиллах нөхцлийг бүрдүүлж дулааны улирлын нормын хувцас, хамгаалалтын каск, савны цэвэрлэгээ үйлчилгээг хийх зориулалтын хамгаалах хувцас хэрэглэлд 893’000 төгрөгийг зарцуулсан байна.

Ажилчдын унаа машин болон тосны цистернд ээлжит урсгал засвар, улсын үзлэг, оношилгоонд хамруулж 1’620’100₮, оффисын бичиг хэрэглэл, принтерийн хор, цэвэрлэгээний материалд 155’880₮, бусад материалд 70’300₮ тус бүр зарцуулсан байна.

Гэрээ хэлцэлүүд болон томоохон худалдан авагчид:

2015 оны тайлант хугацаанд түрээсийн болон санхүүгийн үйл ажиллагаатай холбогдолтой 1 гэрээ, ажил үйлчилгээ үзүүлэх 4 гэрээ, худалдах ба худалдан авахтай холбогдолтой 4 ширхэг гэрээнүүдийг тус бүр байгуулсан байна. 2015 оны эхний хагас жилд хийгдсэн гэрээнүүдийг жагсаавал:

№	Гэрээ байгуулсан компани	Гэрээний агуулга	Эхлэх	Дуусах	Гэрээний үнэ
Түрээс, санхүүгийн үйл ажиллагаатай холбоотой					
1	“БДО Аудит” ХХК	Аудитын ажил гүйцэтгэх			
Ажил, үйлчилгээ үзүүлэх гэрээ					
2	УБТЗ-н ЭХУХ 1-р анги	Цахилгаан хэрэглээний гэрээ	2015/06	2016/06	
3	“Магнай трейд” ХХК	Савны цэвэрлэгээ	2015/05/25	2016/05/25	
4		БОНБУ-г хийлгэх	2015/		
5	Иргэн Отгонбаатар	Мазут тээвэрлэх	2015/05/16	2016/05/16	
Худалдах, худалдан авах гэрээ					
5	“МРЦМ” ХХК	Мазут худалдах	2015/05/15	2015/12/31	24’293’520₮
6	“УВТ инвест” ХХК	Мазут худалдах	2015/05/21	2015/12/01	270’000’000₮
7	“Наранбулаг хан” ХХК	Мазут худалдах	2015/05/25		225’000’000₮
8	“Шунхлай” ХХК	Хаягдал тос худалдан авах	2015/05/19		гэрээ цуцлах хүртэл өөрсдөө тээврийн зардлаа хариуцах

“Шунхлай” ХХК-ний засварын газраас гарч буй техникийн хаягдал тосыг бид өөрсдийн зардлаар засварын газраас нь очиж авахаар тохиролцон гэрээ хийгдсэн.

Он дуустал хийгдэх зүйлс болон борлуулалтын таамаглалын тухайд:

2015 оны үлдсэн хагас жилд борлуулалтын гэрээтэй байгаа “УВТ инвест” ХХК, “Арж капитал” ХХК, Наранбулаг хан” ХХК-дын захиалгын дагуу нийт 750 тонн мазут нийлүүлэхээс 69,6 тонныг гэрээний дагуу өгч үлдэж буй 680 тонн мазутыг богино хугацаанд боловсруулах тул мазут худалдан авах гэрээтэй байгуулагуудын итгэлийг алдахгүйн тулд одоо байгаа түүхий эдийн нөөцөн дээр нэмээд шаардагдах 310 тонн орчим түүхий эдийг нэн түрүүнд буюу богино хугацаанд хуримтлуулсан байх шаардлага тулгараад байна. Үүний тулд бид авто засварын газрууд болон зарим уул уурхайн компани, хувь хүмүүстэй харилцан ашигтай байхаар ярилцаж байна.

Мөн хаягдал тос боловсруулах үйл ажиллагааг сайжруулан мазутаас гадна гидрийн шингэний чанарыг сайжруулан 2016 оноос худалдаанд гаргаж борлуулалтыг нэмэгдүүлэх ажлын туршилт судалгаа хийгдэж байгаа болно.

Үлдсэн хагас жилд дараах ажил үйлчилгээнүүдийг хийхээр төлөвлөөд байна. Үүнд:

1. Өнгөрсөн жил худалдан авсан 3 ш 50м³ савнуудыг чанар стандарт, технологийн дагуу угсарч байрлуулан хуучин тосны паркийн шугам хоолой болон хаалт, жийрэгүүдийг сольж шинэчлэн агуулах паркийн гэрэлтүүлэг, шугам хоолойн дулаалга болон галын аюулгүй байдлыг бүрэн хангасан хаягдал тосны нөөцийн сав, агуулах паркийн засвар, угсралтыг хийж тохижуулах.
2. Галын сарай, галын булан хийх.
3. Лагийн ууршуулах талбайг бэлтгэх.
4. Тос агуулах савнуудын тэмдэг тэмдэглэгээ, хэмжээс, калибровкийг хийлгэж баталгаажуулалтыг хийх.
5. Бусад уул уурхай болон авто засварын газруудад нөөцийн сав байрлуулах ажил.
6. Байгаль орчны менежментийн төсөв, төлөвлөгөөг боловсруулж харъяа дүүргийн БО-ны мэргэжилтэнгээр батлуулах.
7. Өвөлжилтийн бэлтгэл ажил эхлүүлэх.

Хөрөнгө оруулалт, хэрэгжүүлж буй төсөл:

“Хай Би Ойл” ХК Малайз улсад бүртгэлтэй өөрийн охин компани болох НВОil (L) Berhad компанийг БНАСАУ-ын нийслэл Пхеньян хотод нээсэн. НВОil (L) Berhad компани нь БНАСАУ-ын үндэсний газрын тосны хайгуулын компани “Korea Oil Exploration Corp” компанитай хамтарсан төслийн нэг хэсэг болох БНАСАУ-ын эх газрын газрын тосны хайгуулын үйл ажиллагааг явуулах зорилготой юм.

Пхеньян хот дахь Янгагдо зочид буудалд байрлах геологийн мэдээллийн төвийг байгуулсан ба шаардлагатай тоног техник хангамж болон программ хангамжийг суурилуулж улмаар БНАСАУ-д газрын тос байгалийн хийн чиглэлээр хийгдсэн бүх хайгуулын мэдээллүүд, геологи геофизикийн болон техникийн мэдээллүүдийг олж авч нэгтгэх, дахин боловсруулах, хөрвүүлэх ажлуудыг хийж байна.

Компани нь БНАСАУ-д стратегийн хөрөнгө оруулагчдыг урих, бүтээгдэхүүн хуваах гэрээ байгуулах зорилт тавин ажиллаж байна. Гэвч БНАСАУ нь эбола вирусаас шалтгаалан 2014 оны 10 сараас хойш хилээр шууд нэвтрүүлэхийг хориглосон болон хүйтний улирал давхцсан зэргээс шалтгаалан бидний ажил удаашрах нөхцөл үүссэн.

Түүнчлэн нефтийн үнийн бууралт нь тендерт оролцогчдын идэвхийг бууруулаад байгаа ба 2015 оны хагас жилээс зах зээлийн нөхцөл байдал сайжрах хандлагатай байгаа тул 2015 оны хоёрдугаар хагаст виртуал дата төвийг үүсгэж дуусах, олон улсын тендер зарлахын тулд олон улсын хуулийн зөвлөх, нефтийн маркетингийн компаниудыг урьж ажиллуулах төлөвлөгөөтэй байна.

Санхүүгийн тайлангийн үзүүлэлт:

2015 оны эхний хагас жилд 77,109,176 төгрөгийн орлоготой, 63,627,709 төгрөгний өртөгтэй, цалин хөлсний зардалд 135,313,661 төгрөг, нийгмийн даатгалын шимтгэлд

17,590,775 төгрөг, албан томилолтын зардалд 20,087,733, засвар үйлчилгээний зардалд 2,848,300, бусад үйл ажиллагаанд 46,989,265.27 төгрөгийн зардал гаргасан байна.

Ажилчдад 142,728,461 төгрөг, нийгмийн даатгалын байгууллагад 32,711,172 төгрөг, ХХОАТатварт 16,516,276 төгрөг, ОАТатварт 5,385,477 төгрөг, газрын төлбөрт 1,170,180 төгрөг, ҮХЭХАТ –т 4,762,216 төгрөг, НӨАТатварт 6,402,747 төгрөг, аудитын үйлчилгээнд 19,800,000 төгрөг, ашиглалтын зардалд 7,284,635 төгрөг зарцуулсан байна.

2015 оны 2-р улирлын санхүүгийн тайлангийн хураангуй:			
№	а.Үлдэгдлийн тэнцэл	01 сарын 01	06 сарын 30
1	Мөнгө түүнтэй адилтгах хөрөнгө	136,116.68	179,725.98
2	Дансны авлага	2,179,154.68	1,698,184.17
3	Бусад авлага	695,089.20	1,046,762.15
4	Бараа материал	64,632.08	93,892.04
5	Урьдчилж төлсөн зардал тооцоо	108,879.56	121,555.49
6	Эргэлтийн хөрөнгийн дүн	3,183,872.20	3,140,119.82
7	Үндсэн хөрөнгө	1,484,282.27	1,439,984.59
8	Биет бус хөрөнгө	2,843.43	2,034.22
9	Урт хугацаат хөрөнгө оруулалт	5,011,300.00	5,058,172.13
10	Эргэлтийн бус хөрөнгийн дүн	6,498,425.70	6,500,190.90
11	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	9,682,297.90	9,640,310.73
12	Дансны өглөг	230,394.20	231,746.00
13	Татварын өр	9,233.29	45,154.21
14	Богино хугацаат зээл	8,481,544.88	8,481,844.88
15	Хүүний өглөг	335,023.80	335,023.80
16	Бусад богино хугацаат өр төлбөр	224.09	107.30
17	Өр төлбөрийн нийт дүн	9,056,420.26	9,093,576.18
18	Хувийн өмч	923,426.80	923,426.80
19	Нэмж төлөгдсөн капитал	561,193.88	561,193.88
20	Хуримтлагдсан ашиг	(858,743.04)	(937,886.13)
21	Эздийн өмчийн дүн	625,877.64	546,734.55
22	ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧ	9,682,297.90	9,640,310.73
б.Орлого үр дүнгийн тайлан			
23	Борлуулалтын орлого (цэвэр)		77,109.17
24	Борлуулалтын өртөг		63,627.71
25	Нийт ашиг (алдагдал)		13,481.47
26	Хүүгийн орлого		49,038.12
27	Бусад орлого		-
28	Ерөнхий ба удирдлагын зардал		232,686.00
29	Санхүүгийн зардал		-
30	Бусад зардал		1,181.26
31	Гадаад валютын ханшийн зөрүүний олз (гарз)		76,577.74
32	Татвар төлөхийн өмнөх ашиг ((94,769.92)

	алдагдал)		
33	Орлогын татварын зардал		4,903.82
34	Татварын дараах ашиг (алдагдал)		(99,673.75)

Ноогдол ашгийн талаарх мэдээлэл:

Компани 2014 онд ноогдол ашиг тараагаагүй болно.

Компани их хэмжээний хэлцэл хийгээгүй. Сонирхолын зөрчилтэй хэлцэлийг Компанийн тухайн хуулийн 89 дүгээр зүйлийг удирдлага болгон сонирхолын зөрчилтэй хэлцэл, түүнийг хийх журмын дагуу хийсэн.

Үнэт цаас гаргагчийн хяналтын багц эзэмшигчдийн мэдээлэл:

Хувьцааны 5 буюу түүнээс дээш хувийг эзэмшигч этгээд:

№	Хувьцаа эзэмшигчийн нэр	Нийт хувьцааны хувь
1	FIREBIRD GLOBAL MASTER HOLDINGS-2	28,29%
2	БИДИСЕК ХК	19,85%
3	FIREBIRD MONGOL HOLDINGS A.S.A	16,76%
4	ХҮДРЭЭ ӨЛЗИЙСАЙХАН	5,02%

Үнэт цаас гаргагчийн ТУЗ, дэд хороодын тайлан:

Төлөөлөн удирдах зөвлөлийн ердийн гишүүдээр Б.Лхагвадорж, Ө.Хүдрээ, Б.Пүрэвбаатар, Кэйт Беннетт, Ж.Эрдэмбилэг, Д.Даянбилгүүн, хараат бус гишүүдээр Х.Батхишиг, М.Батсүрэн, Д.Даянбилгүүн, Төлөөлөн удирдах зөвлөлийн даргаар Б.Лхагвадорж, Гүйцэтгэх захирлаар Ө.Хүдрээ,Төлөөлөн удирдах зөвлөлийн нарийн бичгийн даргаар Ж.Энхцэцэг нар ажиллаж байна.

Төлөөлөн удирдах зөвлөлийн дарга, гишүүд, нарийн бичгийн дарга, гүйцэтгэх захирал нар 100 хувь компанийн засаглалын сургалтанд хамрагдсан.

Үнэт цаас гаргачийн удирдлага, эрх бүхий албан тушаалтны танилцуулга

№	Овог, нэр	Албан тушаал	Боловсрол
1	Бүрэнмэнд овогтой Лхагвадорж	ТУЗ-ийн дарга, ердийн гишүүн	дээд
2	Өлзийсайхан овогтой Хүдрээ	Гүйцэтгэх захирал, ТУЗ-ийн ердийн гишүүн,	дээд
3	Баярсайхан овогтой Пүрэвбатаар	ТУЗ-ийн ердийн гишүүн, Санхүү эрхэлсэн захирал	дээд
4	Кэйт Беннетт	ТУЗ-ийн ердийн гишүүн	дээд

5	Жүгдэрнамжил овогтой Эрдэмбилэг	ТУЗ-ийн ердийн гишүүн	дээд
6	Халтар овогтой Батхишиг	ТУЗ-ийн хараат бус гишүүн	дээд
7	Мажигсүрэн овогтой Батсүрэн	ТУЗ-ийн хараат бус гишүүн	дээд
8	Сий Кок Хенг	ТУЗ-ийн хараат бус гишүүн	дээд
9	Данзан овогтой Даянбилгүүн	ТУЗ-ийн ердийн гишүүн	дээд
10	Жаргал овогтой Энхцэцэг	ТУЗ-ийн нарийн бичиг	дээд

“Хай Би Ойл” ХК 2015 оны 04 сарын 30-ны өдөр Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг зарлан хуралдуулснаар дараах асуудлыг шийдвэрлэсэн.

1. Компанийн 2014 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх ТУЗ-ийн дүгнэлтийг хэлэлцэн батлах
2. Компанийн аудитын хорооны тайланг хэлэлцэн батлах
3. 2015 оны ажлын төлөвлөгөөг хэлэлцэн батлах
4. ТУЗ-ийн ердийн болон хараат бус гишүүдийг сонгох
5. ТУЗ болон Гүйцэтгэх удирдлагын 2015 оны зардлын төсвийг батлах
6. Компанийн ногдол ашгийн талаар гаргасан ТУЗ-ийн шийдвэрийг хэлэлцэн батлах
7. Компанийн дүрэмд өөрчлөлт оруулах тухай

Хурлаар хэлэлцсэн асуудлуудыг хуралд оролцсон хувьцаа эзэмшигчдийн 100 хувийн саналаар баталсан.

Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар ТУЗ-ийн гишүүдийг сонгосон бөгөөд 2015 оны 05 сарын 13-ны өдөр Төлөөлөн Удирдах зөвлөлийн хурлыг хуралдуулан ТУЗ-ийн дэргэдэх хороодыг дараах бүрэлдэхүүнтэйгээр томилсон.

А.Төлөөлөн удирдах Зөвлөлийн дэргэдэх Аудитын дэд хороог Х.Батхишиг, Б.Пүрэвбаатар, Сий Кок Хенг гэсэн бүрэлдэхүүнтэйгээр байгуулан, Аудитын хорооны даргаар ТУЗ-ийн хараат бус гишүүн Х.Батхишигийг томилсон.

Б. Төлөөлөн удирдах Зөвлөлийн дэргэдэх Цалин урамшууллын дэд хороог Ж.Эрдэмбилэг, Х.Батхишиг, Сий Кок Хенг гэсэн бүрэлдэхүүнтэйгээр байгуулан, Цалин урамшууллын дэд хорооны даргаар ТУЗ-ийн гишүүн Ж.Эрдэмбилэгийг томилсон.

В. Төлөөлөн удирдах Зөвлөлийн дэргэдэх Нэр дэвшүүлэх дэд хороог Кэйт Беннетт, М.Батсүрэн, Х.Батхишиг гэсэн бүрэлдэхүүнтэйгээр байгуулан, Нэр дэвшүүлэх дэд хорооны даргаар ТУЗ-ийн гишүүн Кэйт Беннеттыг томилсон.